



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо 2026.04.30

Дугаар 01

Улаанбаатар хот

Хэзээ: 2026.04.30 ний өдөр 15 цагт

Хаана: “Баянгол ресторан”-ны хурлын зааланд цахимаар хуралдаж мэдээллийг шууд дамжуулж хувьцаа эзэмшигчдэд хүргэлээ. / цахим facebook live/

Хөтлөгч: Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Баянгол зочид буудал Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит 33-р хурал эхлэхэд бэлэн боллоо.

Хурлыг нээн, хурлын бэлтгэл ажлын талаар танилцуулна уу хэмээн ТУЗ-ын гишүүн Аюуш таныг урья.

ТУЗ-н дарга:Б.Аюуш:

Сайн байцгаана уу. Эрхэм хувьцаа эзэмшигчдээ.Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.. Баянгол зочид буудал ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Цахим хэлбэрээр эхлэхэд бэлэн болоод байна.

Тус компанийн ТУЗ 2026 оны 03 сарын 17-ний өдөр хуралдаж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 сарын 30 ний өдрийн 15:00 цагт өөрийн байранд цахимаар зохион байгуулахаар шийдвэрлэж ТУЗ-ийн тогтоолоор баталгаажуулсан.Уг тогтоолд хурлаар хэлэлцэх асуудлыг баталж хурал оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдрийг тогтоож хурлын бэлтгэлд олон нийтэд зарлах өдрүүд, хурлын баримт бичгийн хүргүүлэх өдрийг товлон, санал дараах хуудасны загварыг баталгаажуулж, тооллогын комиссын бүрэлдэхүүнийг сонгож, хурал зохион байгуулах комиссын даргаар миний бие томилогдсон.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг хавсралт материалуудын хамт Санхүүгийн зохицуулах хороо,Монголын хөрөнгийн биржид хүргүүлж өөрийн цахим сайт байршуулж хувьцаа эзэмшигчдийг хурлын баримт бичигтэй танилцах боломжийг олгов.

Хурал зохион байгуулах комисс бэлтгэл ажлын хүрээнд ТУЗ-с баталсан зар хүргэх загварын дагуу хурлын зарыг 3 сарын 24, 4 сарын 08-д Өдрийн сонин, Монголын мэдээ сонин С1 телевизээр тус бүр 2 удаа хуралдаж буй өдөрд хүргэсэн..

Мөн хуралд оролцох эрх бүхий гишүүдийн жагсаалтыг ҮЦТТХАлбанаас 4 сарын 10-наар гаргуулж авсан.

Хурлаар хэлэлцж хуралдаж буй материалын танилцуулгыг МХБ-ийн цахим хуудсанд байрлуулж мөн өөрийн [info@bayangol.com.mn](#) хаягт байршуулж хувьцаа эзэмшигчдэд танилцах боломжийг олгосон. Мөн компанийн удирдлагын багтай хамтран хийх ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг танилцуулна талаа. Ээлжит хурлыг компанийн ТУЗ-н гишүүд, Удирдлагын баг тооллогын мөн хавсралт - хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн дарга Аюуш удирдан явуулна. Хурлын

үйл ажиллагааг Баянгол цахим хуудсаар дамжуулна. Ингээд хуралдаа идэвхтэй оролцохыг нийт гишүүддээ хүсье.

Хөтлөгч: Тооллогын комиссын гишүүн Т.Удвал хуралд оролцох гишүүдийн ирцийг танилцуулах болно

Т.Удвал : Тооллогын комиссыг төлөөлөн хурлын ирцийг танилцуулж байна. Баянгол зочид буудал ХК-н хувьцаа эзэмшигчдийн 33-р хуралд саналын эрхтэй 381,133 ширхэг хувьцаа эзэмшсэн 1031 хувь нийлүүлэгчдээс 346,173 ширхэг хувьцаа эзэмшсэн хувь нийлүүлэгчид саналаа ирүүлсэн бөгөөд нийт хувьцааны 90,83% төлөөлж байгаа тул компанийн тухай хуулийн 69,1-р зүйл компанийн дүрмийн 7.4 зүйлийг үндэслэн хурлыг хүчин төгөлдөр тооцож байгааг мэдэгдэж байна.

Хөтлөгч : Ийнхүү хурлын ирц бүрдсэн байгаа тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг эхлүүлж хурлыг дэгийг танилцуулна уу хэмээн ТУЗ -ийн дарга Б.Аюуш таныг урьа.

Б.Аюуш: Хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн амар амгаланг эрье. Сая тооллогын комисс танилцуулснаар хурлын ирц 90,83% болсон тул компанийн тухай хуулийн 69, дүрмийн 7,4 заалтын дагуу хурлын ирц хүчин төгөлдөр болсон тул хурлыг эхлүүлье. Хурлын дэгийг хурал хуралдуулах тухай ТУЗ-н шийдвэрээр баталсныг танилцууллаа та бүхэн дэлгэцэд анхаарлаа хандуулна уу.

Хөтлөгч: Хурлын дэгийн дагуу Компанийн 2025 оны Үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар Ерөнхий менежер Н.Батцэнгэл танилцуулна.

Н.Батцэнгэл: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Баянгол зочид буудал ХК нь 1964 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн. Зочлох үйлчилгээний анхдагч байгууллага 1991 онд анхны хувьцаат компани, Олон улсын АА сүлжээний менежментийг нэвтрүүлсэн олон улсын экспертийг анх ажиллуулсан. 1994 онд найдвартай татвар төлөгч хаягийг анх авч байсан, 2016 онд өөрийн нэрийн 4 үндсэн бүтээгдэхүүн Хуйцай зэргийг зохиогчийн эрхээр баталгаажуулсан. 2019 онд ISO9001:2015 Чанарын Менежментийн стандартыг хангасан /IDO/ үндэсний анхны зочид буудал болсон, 2024 онд дахин баталгаажуулсан зэрэг түүхэн ажмжилтуудаараа 1964 оноос өнөөг хүртэл тогтвортой үйл ажиллагаа явуулж зочлох үйлчилгээний анхдагчаар түүчээлж яваа байгууллага болно.

2025 онд 1,8 тэр бум төгрөгийн татварыг төлсөн байна.

2025 он бидний хувьд онцлог жил байсан. Тухайлбал:

- 60 жилийн түүхт ойгоо ахмад үе, одоо үе, харилцагч үйлчлүүлэгч зочдын хүрээнд үе шаттай зохион байгуулж, ажил үйлчилгээгээ сурталчлан тэмдэглэн өнгөрүүлээ
- 60 удаагийн буфет үйлчилгээг гаргаж үйлчилсэн ба энэ нь үйлчлүүлэгчдэд хүрсэн гэж үзэн үүнийгээ 2026 онд Амралтын өдрүүдэд гаргахаар үргэлжлүүлэн үйлчилж зочид хэрэглэгчдэд хүргээд байна.
- Маркетингийн ажлуудыг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн
- Зочид буудлын өрөө борлуулалтыг тухайн цаг үеийн нөхцөлтэй уялдуулан үнийн уян хатан бодлого барьж ажилласан

- Онлайн борлуулалтын хэд хэдэн сувгуудыг ашиглан зочид үйлчлүүлэгчдэдээ хүлээн авснаар үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлсэн.
- Өөрийн нэрийн уламжлалт арга хэмжээ болсон “NAADAM FIESTA”-2025 арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.
- Зочдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан засвар шинэчлэлийг хийж ирлээ
- Хөрөнгө оруулалтад 525 сая. төгрөгийг зарцуулсан бөгөөд их засварыг салбарын техник технологитой холбогдуулан хийж ажилласан .
- Б буудлын өрөөнүүд болон дээврийн хэсэгт хэсэгчлэн засвар хийсэн
- “High Tea”кофе шоп шинээр байгуулж иж бүрэн тохижуулсан
- TP-Link сүлжээний багц тоног төхөөрөмж суурилуулсан
- Угаалгын цехэд угаагч, хатаагч, индүүг шинээр авч байршуулсан.
- Шаардлагатай өрөөнүүдэд эйркондишн угсарч суурилуулсан
- Рестораны бүх шил сав хэрэглэлээ шинэчилсэн

Хүний нөөц, Нийгмийн хариуцлагын хүрээнд

Бидний хамгийн чухал асуудал бол хангалттай ажиллах хүчний нөөцтэй байх асуудал юм. Энэ хүрээнд бид мэргэжлийн сургалт үйлдвэрлэлүүдтэй хамтран ажиллаж мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, сургаж дадлагажуулах ажлыг амжилттай зохион байгуулж байна. Ажилчдын сургалт хөгжүүлэлтийн хүрээнд онцгой байдлын бэлэн байдал, амьдралын эрүүл дадал зуршлыг төлөвшүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах, чиглэлээр сургалтуудыг зохион байгуулж, ажилтнуудын мэдлэг ур чадвар, харилцаа хандлагыг нэмэгдүүлэхэд анхааран ажилласан. Тус зочид буудал нь өөрийн ажилчдын зэрэгцээ нийгэмд тус нэмэр болохуйц ажлуудыг хийсээр ирсэн. Үүнээс зармыг дурдвал:

- Японы “HEART SAVING PROJECT” буюу “Зүрх хамгаалах төсөл “-ийн багтай хамтран ажиллаж хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлсээр байгаа
- Олимпын төрлийн спортыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж спортын баг хамт олныг дэмжиж хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж байна. Үүнд: Монголын хөл бөмбөгийн холбоо, Жүдо бөхийн холбоо, Боксын холбоо, Таеквондогийн холбоо, Шатрын холбоо зэрэг холбоотой хамтраг ажиллаж байна.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд хараагүй хүмүүсийн эрхийг хамгаалах Дэлхийн цагаан таягтаны өдрийг тохиолдуулан харааны бэрхшээлтэй хүмүүст сайхан сэтгэлийн гараа сунгаж хандив тусламж үзүүлсэн.

2026 онд “Таны эрхэм мөч бүрийг төгөлдөржүүлнэ “ урианы дор

- Үндэсний зочид буудал үндэсний үйлдвэрлэлээ дэмжих
- Орлогыг нэмэгдүүлэх Борлуулалтын жил
- Үйлчилгээний чанараа сайжруулах
- Ногоон хөгжил тогтвортой хөгжлийн хүрээнд 1 удаагийн хэрэгслийг багасгах
- Олимпын спортуудыг дэмжин ажиллах зэрэг зорилтуудыг тавин ажиллаж байна.

Хөтлөгч: Тайланг танилцуулж дууслаа. Компанийн 2025 ажилд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг танилцуулна уу хэмээн ТУЗ-н дарга Б.Аюуш таныг урьж байна.

Б.Аюуш: Үл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонслоо. Баянгол зочид буудал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Баянгол зочид буудал” ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар баталж, уг журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

2025-2026 онд ТУЗ нь хууль, компанийн дүрэм болон дээрх журмаар тогтоосон эрхийн хүрээнд доорх асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн болно. Үүнд:

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг улирал, жилээр хэлэлцэн чиглэл өгч, Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах, Компанийн үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах, компанийн удирдлагын багт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах, компанийн Гүйцэтгэх захирлын ажилд үнэлгээ өгөх, гэрээ хийж, дүгнэх, аудитын байгууллагыг сонгох, ногдол ашиг хуваарилах, ТУЗ-ийн гишүүдэд сургалт явуулах зэрэг компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтоосон асуудлуудыг хэлэлцэж, хурлын тэмдэглэл, тогтоол гарган хэрэгжилтийг хангаж ажилласан болно.

Ингээд Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дах заалтын дагуу

1. Компанийн гүйцэтгэх удирдлагаас 2025 онд хийж гүйцэтгэсэн ажлыг “хангалттай сайн” гэж дүгнэж, гүйцэтгэх захиралтай байгуулсан контракт гэрээг сунгах;
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд компанийн үйл ажиллагааны гүйцэтгэл, санхүүгийн байдлыг бодитой тусгасан байна гэж үзэж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахаар шийдвэрлэн тогтоол гаргасан.

Мөн Тус зочид буудлын 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд “Сэрэлт дөл аудит” ХХК аудит хийж “хангалттай” гэж дүгнэсэн

Хөтлөгч: ТУЗ-н төсөвийг танилцуулна уу хэмээн ТУЗ-н гишүүн З.Цэрэнчимэг таныг урьж байна.

З.Цэрэнчимэг: ТУЗ-н төсвийг танилцуулав. Нийт төсөв 53,740,000 төгрөг болно. Үүний задаргаа нь гишүүдийн цалин, нийгмийн даатгал, үйлчилгээний хураамжууд, хурал зохион байгуулахтай холбоотой зардлууд багтсан байна.

Хөтлөгч: Хурлаар хэлэлцэх асуудлууд үүгээр дуусаж байна. Одоо хувьцаа эзэмшигчдийн ирүүлсэн асуултуудыг танилцуулъя.

Хөтлөгч: Үүнд info@bayangolhotel.mn -д доорх асуултууд ирсэн бөгөөд асуултыг танилцуулъя. Холбогдох хүмүүс хариулж өгнө үү. Үүнд :

1. 10 хувьцаа эзэмшигч Д.Чимгээ “ 2025 оны ноогдол ашгийг хэзээ өгөх вэ”
2. 32ш хувьцаа эзэмшигч Х.Суурьтогтох: “Аялал жуулчлалын салбарт хүний нөөцийн хомсдол их байгаа ажиллах хүчээ хэрхэн хангаж байна вэ?
3. 35ш хувьцаа эзэмшигч Ц.Аюурзана: Хурлын материалтай танилцлаа. 2026 оны зорилтдоо “Үндэсний ууган зочид буудал хэв шинжээ тодотгон борлуулалтын жил болгохоор төлөвлөж

үндэсний брэндүүдтэй хамтран ажиллах талаар тусгасан нь хамгийн үр дүнтэй үйл ажиллагаа байна гэж үзэж байна. Амжилт хүсье.

4. 10ш хувьцаа эзэмшигч: А.Мөнхжаргал” 2026 онд зочны тоо урьдчилсан байдлаар хир прогнозтой байгаа вэ. COP-17 ийн зочид буухаар байгаа юу

Хариулт:3.Цэрэнчимэг: Уг асуултад хариулахын өмнө хуулиар тогтоосон шаардлагын дагуу Ногдол ашгийг ТУЗ тогтоож, Хувьцаа эзэмшигчдийн хурал танилцуулах үүрэгтэй тул 2026 оны 2 дугаар сарын 16-ны 01 тоот тогтоолыг уншиж танилцуулъя. Уг тогтоолоор нэгж хувьцаанд 330 төгрөг олгож 2026.05.01нээс олгож эхлэхээр тогтоосон болно.

Гэрэлмаа: Үндэсний брэндүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа. COP-17 ийн хувьд бол одоогоор урьдчилсан захиалгууд байгаа боловч одоогоор баталгаажуулаагүй байна. Бид жуулчны компаниудын зэрэгцээ Монголд зохион байгуулагдах уралдаан тэмцээнүүдтэй хамтран ажиллахаар гэрээ байгуулсан байгаа.

Оюунчимэг: Мэргэжилтэй ажиллах хүчнээр хангах тухайд идэвхтэй ажил хайж байгаа ажил горилогч нарыг зарын мэдээллээс тогтмол сонгох, гадаад ажилтан авч ажиллуулах, мөн мэргэжлийн сургуулийн оюутнуудыг цалинтай дадлага хийлгэх, Их дээд сургуулийн оюутнуудыг цагаар ажиллуулах зэргээр бүрдүүлж ажиллаж байна.

Хөтлөгч: ТУЗ-н дарга Б. Аюуш таныг урьж байна.

Б.Аюуш: Хурлаар танилцуулах асуудал дууслаа хувьцаа эзэмшигчээс ирсэн асуултад хариуллаа. Тооллогын комисс ажилдаа орно уу

Хөтлөгч: Саналын хуудсаа тоолж дууссан тул тооллогын комиссын дарга Д.Оюунчимэг та тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулна уу

Д.Оюунчимэг: Баянгол зочид буудал ХК-н ХЭХ-н тооллогын комиссын тогтоол 2026 оны 4 сарын 30

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

1. Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт 63 дугаар зүйлийн 63.5 заалт, 67 дугаар зүйлийн 3.8 заалтыг үндэслэн тогтоох нь . Компанийн 2025 оны үйл ажиллагаа санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг хэлэлцэх батлах асуудлаар нийт өгсөн санал 346173 үүнээс татгалзсан 0, түдгэлзсэн 0, зөвшөөрсөн 346173 санал өгсөн нь нийт саналын 100%-н саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон
2. Компанийн ТУЗ-н зардлын төсвийг батлах асуудлаар нийт өгсөн санал 346173, үүнээс татгалзсан түдгэлзсэн байхгүй зөвшөөрсөн 346173 санал өгсөн нь нийт саналын 100%-н саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсныг мэдэгдсүгэй

Комиссын дарга Д.Оюунчимэг

Хөтлөгч: Хурлаас гарах тогтоолыг ТУЗ-н дарга Б.Аюуш та уншиж танилцуулна уу.



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо

Дугаар

Улаанбаатар хот

Аюуш: Энэ хурлаар 2 асуудал хэлэлцэх ёстой

1. Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ дүгнэлтийг батлах
2. ТУЗ-н төсвийг батлах

ТУЗ-н дүгнэлт :Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн дүгнэлт, ТУЗ-н төсөвийг хавсралтаар батлав.

Хурлаас гарах тогтоолыг танилцуулаад хурлыг хаалаа.

ХУРЛЫН ДАРГА:  Б.АЮУШ

ПРОТОКОЛ БИЧСЭН:

 Д.ОЮУНЧИМЭГ

 Д.ГАНЧИМЭГ